



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН ТӨҮГ-ЫН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/86/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Аудитор: Б.Энхжин
Утас: 260512 Цахим хаяг: enkhjinb@audit.gov.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн: Эс Жи Эм Ди Аудит ХХК
Захирал: Д.Эхбаяр
Утас: 7000 6948 Цахим хаяг: ekhbayar@sgmd-audit.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	9
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	10
4.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	10
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	11
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	13
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
8. Аудитын илрүүлэлт	14
8.1 Албан шаардлага	14
8.2 Зөвлөмж	14
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчид үйлдвэрийн газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭМНДШ	Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын шимтгэл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН
ХҮРЭЭЛЭНГИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
М.ТҮМЭНЖАРГАЛ ТАНАА

2022.03.15 № 07/58.1

танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын тайлан

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 588.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшнээс их байгаа нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байх”, “иж бүрэн байх”, эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 638 дугаар тогтоолоор Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 2,302.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 2,107.2 сая төгрөгөөр, ашгийг 194.8 сая төгрөг байхаар баталсан байна.

Гүйцэтгэлээр 3,154.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,865.9 сая төгрөгийн зардал гарган, 1,288.1 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 22 зорилтын хүрээнд 178 арга хэмжээг төлөвлөснөөс 172 арга хэмжээг бүрэн гүйцэтгэж, жилийн ажлын дундаж гүйцэтгэл 96.9 хувьтай гэж тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	318,779,104.91	1,136,615,651.04
1.1.2	Дансны авлага	383,787,815.12	258,765,161.66
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	4,410,111.35	11,658,538.96
1.1.4	Бусад авлага	282,140,000.00	338,018,650.00
1.1.6	Бараа материал	81,154,569.47	85,130,358.46
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,070,271,600.85	1,830,188,360.12
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	989,249,689.73	925,445,029.08
1.2.2	Биет бус хөрөнгө	260,180,431.31	265,616,138.76
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,249,430,121.04	1,191,061,167.84
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,319,701,721.89	3,021,249,527.96
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.3	Татварын өр	2,408,819.94	26,701,979.33
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	13,355,726.27
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	240,400,000.00	313,547,540.54
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	242,808,819.94	353,605,246.14
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	3,141,956.04	3,851,639.64
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	3,141,956.04	3,851,639.64
2.2	Өр төлбөрийн нийт дүн	245,950,775.98	357,456,885.78
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн		
2.3.2	хувийн		
2.3.3	хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	122,828,899.86	122,828,899.86
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	92,192,981.37	92,192,981.37
2.3.9	Хуримтлагдсан ашиг	945,010,287.06	1,535,051,983.33
2.3.9.1	Тайлант үеийн ашиг		606,909,216.72
2.3.9.2	Өмнөх үеийн ашиг	945,010,287.06	928,142,767.06
2.3.11	Эздийн өмчийн дүн	2,073,750,945.91	2,663,792,642.18
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,319,701,721.89	3,021,249,527.96

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,783,983,859.49	3,009,299,166.96
2	Борлуулалтын өртөг	234,739,991.32	634,895,421.60
3	Нийт ашиг(алдагдал)	1,549,243,868.17	2,374,403,745.36
5	Хүүгийн орлого	4,263,314.59	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,359,713,667.06	1,680,264,144.16
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(5,300,112.24)	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	199,093,627.94	694,139,601.20
19	Орлогын татварын зардал	30,418,469.48	87,230,384.93
20	Татварын дараах ашиг (алдагдал)	168,675,158.46	606,909,216.27
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	168,675,158.46	606,909,216.27

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	/төгрөгөөр/	
				Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	913,718,777.62	111,172,099.86	91,992,981.37	877,915,128.60	1,994,798,987.45
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(89,080,000.00)	(89,080,000.00)
Залруулсан үлдэгдэл	913,718,777.62	111,172,099.86	91,992,981.37	788,835,128.60	1,905,718,987.45
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	168,675,158.46	168,675,158.46
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	200,000.00	-	200,000.00
Зарласан ногдол ашиг	-	-	-	(12,500,000.00)	(12,500,000.00)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	11,656,800.00	-	-	11,656,800.00
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	913,718,777.62	122,828,899.86	92,192,981.37	945,010,287.06	2,073,750,945.91
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	606,909,216.27	606,909,216.27
Зарласан ногдол ашиг	-	-	-	(16,867,520.00)	(16,867,520.00)
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	913,718,777.62	122,828,899.86	92,192,981.37	1,535,051,983.33	2,663,792,642.18

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,793,087,091.14	3,301,943,286.60
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,716,163,362.45	3,237,935,431.68
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	105,000.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	10,176,438.00	28,311,628.00
	Буцаан авсан албан татвар	-	-
	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
	Бусад мөнгөн орлого	66,747,290.69	35,591,226.92
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,643,020,136.71	2,417,268,920.47
	Ажиллагчдад төлсөн	681,367,509.94	778,519,551.91
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	220,643,202.54	260,531,733.60
	Бараа материал худалдан авахад төлсөн	31,074,962.70	27,876,439.00
	Ашиглалтын зардалд төлсөн	40,253,579.55	41,355,737.65
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	50,332,756.00	59,927,916.55
	Хүүгийн төлбөрт төлсөн	-	-
	Татварын байгууллагад төлсөн	163,896,837.25	197,260,947.80
	Даатгалын төлбөрт төлсөн	17,278,250.00	34,834,059.00
	Бусад мөнгөн зарлага	438,173,038.73	1,016,962,534.96
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	150,066,954.43	884,674,366.13
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,263,314.59	-
	Хүлээн авсан хүүгийн орлого	4,263,314.59	
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	86,495,271.84	49,820,300.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	82,130,727.29	49,820,300.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,364,544.55	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(82,231,957.25)	(49,820,300.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	12,500,000.00	16,867,520.00
	Төлсөн ногдол ашиг	12,500,000.00	16,867,520.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(12,500,000.00)	(16,867,520.00)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	55,334,997.18	817,986,546.13
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	263,444,107.73	318,779,104.91
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	318,779,104.91	1,136,615,651.04

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 он		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт						
	а/ Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	мян.төг	189,027.2	595,000.0	627,293.0	32,293.0	105.4
	Зураг төсөл боловсруулах ажил	мян.төг	380,204.1	882,043.9	863,796.3	(18,247.6)	97.9
	Норм, норматив боловсруулах	мян.төг	477,215.8	300,000.0	303,820.3	3,820.3	101.2
	Тусгай зөвшөөрлийн үйлчилгээ үзүүлэх ажил	мян.төг	737,536.8	525,000.0	1,359,100.0	834,100.0	258.9
	Бусад орлого	мян.төг	9,563.4	-	-	-	0
	б/ Үнийн дүнгээр	мян.төг	1,793,547.3	2,302,043.9	3,154,009.6	851,965.7	137
2	Нийт орлого	мян.төг	1,793,547.3	2,302,043.9	3,154,009.6	851,965.7	137
	Үүнээс: цэвэр борлуулалт	мян.төг	1,783,983.8	2,302,043.9	3,154,009.6	851,965.7	137
3	Нийт зардал	мян.төг	1,594,453.7	2,107,212.1	1,865,884.8	(241,327.3)	98.4
	Үүнээс: Ерөнхий ба удирдлагын зардал	мян.төг	65,924.3	73,941.8	72,280.0	(1,661.8)	97.7
	Мэргэжлийн ажил үйлчилгээний зардал	мян.төг	233,918.3	502,189.5	411,438.4	(90,751.1)	8169
	Тусгай зөвшөөрөл эзэмших эрх олгох бэлтгэл ажил хангах зардал	мян.төг	108,546.8	131,696.0	131,217.7	(478.3)	99.6
4	Татварын өмнөх ашиг	мян.төг	199,093.6	194,831.8	1,288,124.7	1,093,329.3	661.1
5	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	168,675.1	175,348.6	1,159,312.3	983,963.7	661.1
6	Төсвийн төлбөрт нийт дүн	мян.төг	373,224.9	423,517.9	259,791.6	(163,726.3)	61.3
7	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	12,500.0	35,069.7	16,867.5	(18,202.2)	48.1
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	36	41	36	(5)	87.8
9	Нийт цалингийн сан	мян.төг	824,890.9	1,006,877.4	901,168.1	(105,709.3)	89.5
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	мян.төг	1,099.4	2,046.5	2,086.0	-	-
11	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	мян.төг	0.9	0.9	0.6	-	-
12	Хөрөнгө оруулалт	мян.төг	84,830.0	83,400.0	83,900.3	500.0	100.5
13	Авлага	мян.төг	670,337.9	350,000.0	537,302.0	187,302.0	153.5
14	Өглөг	мян.төг	245,950.8	100,000.0	353,605.2	253,605.2	353.6
15	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	242,808.8	100,000.0	353,605.2	253,605.2	353.6
	Урт хугацаат өр төлбөр	мян.төг	-	-	-	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага түүний орчин, дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, бодлого үйл ажиллагаа, дотоод хяналттай холбоотой асуудлуудын талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 15-аас 2022 оны 3 дугаар сарын 15-ны хооронд Эс Жи Эм Ди Аудит ХХК-ийн аудитын менежер Д.Насанжаргал, ахлах аудитор О.Алтанцэцэг, Д.Жаргалсайхан, аудитор О.Ганчимэг, аудитын шинжээч Ч.Ням-Очир нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Б.Оюунцэцэг, захирал Д.Эхбаяр нар хэрэгжүүлсэн.

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ нь 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газар (Эс Жи Эм Ди Аудит ХХК)-т 2022 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 01/48 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ нь хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын нэгжгүй бөгөөд тайлант онд Эрчим хүчний яамны хяналт шинжилгээ дотоод аудитын газраас хяналт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт зардал 2,319.7 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 46.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 37.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын зорилго нь Монгол Улсын эрчим хүчний салбарын ойрын болон хэтийн хөгжлийн судалгаа хийх, эрчим хүчний байгууламжийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төсөл хөтөлбөрүүдийг боловсруулах, норм, норматив, стандартыг боловсронгуй болгох, эрчим хүчний хэмнэлтийн менежмент, инновац нэвтрүүлэх замаар төрийн захиргааны Төв байгууллагын захиалга, үүрэг даалгаврыг ханган ажиллах гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд, төрийн өмчит үйлдвэрийн газар гэсэн статустай байна. Өмчийн 100.0 хувийг төр, үүнээс ТӨБЗГ 100.0 хувийг эзэмшиж байна.

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээний таац боловсруулах, эрчим хүчний бодлого, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, тодотгоход шаардлагатай тооцоо, судалгаа, эрчим хүчний балансын судалгаа хийх;
2. Мэргэжлийн түвшинд гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, судалгааны материал, мэдээллээр эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг хангах;
3. Эрчим хүчний байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулах, зохиогчийн хяналт тавих, магадлал хийх;
4. Хэрэглэгчдийн эрчим хүчний хэрэглээний үр ашгийг тооцох, дүгнэлт гаргах, алдагдлыг бууруулах, эрчим хүч хэмнэх талаар судалгаа хийх, хэмнэлтийн менежментийг нэвтрүүлэх, эрчим хүчний аудитын үйл ажиллагаа эрхлэх;
5. Салбарын хөгжлийн төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын үр ашгийг урьдчилан тооцож төслийг оновчтой болгох, үнэлэлт дүгнэлт гаргах;
6. Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөх стандарт, нормативын баримт бичиг, техникийн зохицуулалтыг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах;
7. Байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний шинэ техник, технологи, инновацыг судлах, нэвтрүүлэх, нутагшуулах талаар судалгаа хийх;
8. Гадаадын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагатай хамтран ажиллах, шинэ техник, технологи, ноу хауг харилцан солилцож туршлагаа хуваалцах, сургалт, семинар, зөвлөгөөн зохион байгуулах, мэдээллээр холбогдох байгууллагуудыг хангах;
9. Эрчим хүчний салбарт гадаадын зээл, тусламж, гадаадын хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн техник хяналтыг зохион байгуулах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх;
10. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.8.2, 15.8.5 дахь заалтуудад заасан тусгай зөвшөөрөл олгох асуудлаар урьдчилсан дүгнэлт гаргах үйл ажиллагааг зохион байгуулах;
11. Үйл ажиллагааны явцад боловсруулагдсан баримт бичгүүдийг нэгтгэж, мэдээллийн сан, архивын нэгж бүрдүүлэх;
12. Эрчим хүчний салбарын ажилтнуудыг гадаад, дотоодод сургах, туршлага судлуулах, хурал, семинар, үзэсгэлэнд оролцуулах, зохион байгуулах;
13. Хүрээлэн нь бүрэлдэхүүндээ эрдэм шинжилгээ судалгааны төв, салбар нэгж, туршилт, судалгаа, үйлдвэрлэл, тохируулгын лаборатори полигон сорилтын цех, аж ахуйн үйл ажиллагаа явуулах нэгжтэй байж болно.

14. Хүрээлэнгийн үндсэн зорилтод нийцсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэсэн бизнесийн үйл ажиллагаа эрхлэх;
15. Хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ыг 1998 онд Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр байгуулагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах; ” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлагыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас томилж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11.6, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолын заалттай нийцэж байна.

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-т Төлөөлөн Удирдах Зөвлөл томилогдоогүй байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д заасны дагуу ерөнхий ба удирдлагын зардлыг 2.2 хувь, мэргэжлийн ажил үйлчилгээний зардлыг 18.0 хувиар тус тус бууруулж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хууль
- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх тэмцэх нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаал “Журам шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 103 дугаар тушаал “Журам батлах тухай”;

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	318,779.1	1,136,615.6	817,836.5
Авлага	670,337.9	608,442.3	(61,895.6)
Бараа материал	81,154.6	85,130.4	3,975.8
Үндсэн хөрөнгө	989,249.7	925,445.0	(63,804.7)
Биет бус хөрөнгө	260,180.4	265,616.1	5,435.7
Нийт хөрөнгийн дүн	2,319,701.7	3,021,249.5	701,547.8
Өр төлбөрийн дүн	245,950.8	357,456.9	111,506.1
Богино хугацаат өглөг	242,808.8	353,605.2	110,796.4
Урт хугацаат өглөг	3,141.9	3,851.6	709.7
Эздийн өмч	2,073,750.9	2,663,792.6	590,041.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,319,701.7	3,021,249.5	701,547.8

Касс дахь бэлэн мөнгө 0.3 сая, банк дахь харилцах дансанд 1,136.2 сая төгрөг байна.

Авлага дансны үлдэгдэлд 258.7 сая төгрөгийн дансны авлага, 11.6 сая төгрөгийн НӨАТ-ын авлага, 338.0 сая төгрөгийн бусад авлага бүртгэлтэй байна.

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны хүрээнд үүссэн байгууллагаас авах авлага 125.0 сая төгрөгөөр барагдаж авлагын бууралтад голлон нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 608.4 сая төгрөгийн, хугацаа хэтэрсэн найдваргүй авлага байхгүй байна.

Үндсэн хөрөнгө худалдан авсан 49.6 сая төгрөгөөр нэмэгдэж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны А-1/1640 тогтоолоор Эрчим хүчний яаманд балансаас баланст шилжүүлсэн 9.8 сая, тайлант оны элэгдлийн зардал 94.9 сая төгрөгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө 5.4 сая төгрөгийн худалдаж авсан дүнгээр өсжээ.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд ААНОАТ-ын 13.6 сая, ХХОАТ-ын 13.1 сая, НДШ-ийн өглөг 13.4 сая, урьдчилж орсон 313.6 сая төгрөгийн орлого нийт 353.6 сая төгрөгийн өглөгтэй байна.

Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 3.8 сая төгрөгийн хойшлогдсон татварын өр бүртгэлтэй байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зардлын хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээг ирээдүйд байгууллагад эдийн засгийн үр ашиг, өгөөж бий болгох боломжтой, дүн эсвэл өртгийг найдвартай үнэн зөв хэмжиж болох бол хүлээн зөвшөөрч тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал, борлуулалт маркетингийн зардал, ерөнхий ба удирдлагын зардал гэж ангилсан байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын гүйцэтгэх байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 638 дугаар тогтоолоор Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 2,302.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 2,107.2 сая төгрөгөөр, 194.8 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 83.4 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 3,154.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,865.9 сая төгрөгийн зардал гарган, 1,288.1 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 3,154.0 сая төгрөг болж төлөвлөснөөс 851.9 сая төгрөг буюу 37.0 хувиар давсан нь тусгай зөвшөөрөл олголтын тоо хэмжээ нэмэгдсэнээс нөлөөлжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 1,865.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 241.3 сая төгрөг буюу 88.7 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна.

2021 оны хөрөнгө оруулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 3 нэр төрлийн хөрөнгө оруулалтын ажилд өөрийн эх үүсвэрээс 83.9 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд тухайн байгууллагын хөрөнгөөр ЭХЯ-д цахим хурлын заалны тоног төхөөрөмж 8.6 сая, зөөврийн компьютер 2.2 сая, суурин компьютер 5.4 сая, скайнер 0.9 сая нийт 17.1 сая төгрөгийг хөрөнгийг худалдаж авч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрлөөр балансаас баланст шилжүүлэн өгсөн байна.

ТӨБЗГ-ын 2021 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 288 дугаар тогтоолын дагуу ашгийн 10 хувь буюу 16.8 сая төгрөгийн ногдол ашгийг ТӨБЗГ-т төвлөрүүлсэн байна.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт мэргэжлийн үйлчилгээний зардал, тусгай зөвшөөрлийн эрдэм шинжилгээний хурлын зардлуудыг багтаасан байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант онд нийт 3,668.1 сая төгрөгийн 199 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 107.9 сая төгрөгийн 14 мэдээллийг байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд; 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх; “ 6 дугаар зүйлийн 6.4.4 “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;”, Засгийн газрын 2016 оны 29 дугаар тогтоолын 4.1.7 “хөрөнгийн болон урсгал зардалд тусгасан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг тендерийн хорооны дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор энэ журмын 7 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар;” гэсэн заалттай нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 341.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 326.8 сая төгрөгийн зөрчлийг арилгасан, 14.3 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 137.5 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгснөөс албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	5	137.5	5	137.5	-	-	100
Зөвлөмж	2	-	2	-	-	-	100
Нийт дүн	7	137.5	7	137.5	-	-	100

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар Эрчим хүчний яамны 2021 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн в/2540 дугаар албан бичгийн дагуу “Эрчим хүчний барилга, засварчдын холбоо” ТББ, “Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо” ТББ-ын түншлэлтэй байгуулсан 60.0 сая төгрөгийн зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж, тусгай зөвшөөрөл олгож байгаа асуудлыг дараагийн аудитаар үзнэ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 588.9 сая төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс 403.4 сая төгрөгийн 4 алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, 185.5 сая төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 588.9 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 37.1 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан тул “Хязгаарлалттай” санал дүгнэлт өглөө.

8.1 Албан шаардлага

1. Мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлтэй байхад НДШ-ийн 13.3 сая төгрөг, ХХОАТ-ын 13.1 сая төгрөгийн өртэй гарсан байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйл, “Нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам 1. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ.” гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаагүй, тохиолдсон байх, үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант онд Барнаб ХХК-тай 75.6 сая төгрөг, Интернэшнл повер ХХК-тай 56.0 сая төгрөг, Ричвел инженеринг ХХК-тай 146.4 сая төгрөг нийт 278.5 сая төгрөгийн зөвлөх үйлчилгээний ажлыг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.” заалт, Засгийн газрын 2021 оны 124 дугаар тогтоолтой тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Тайланд онд бусдаар гүйцэтгүүлсэн ажил буюу мэргэжлийн үйлчилгээний зардлаас 98.4 сая төгрөгийн гэрээт ажлыг сонгон шалгаруулалт хийгээгүй, иргэдтэй шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.” заалт, Засгийн газрын 2021 оны 124 дугаар тогтоолтой тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

8.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд банканд дахь харилцах данснаас 91.1 сая төгрөг бэлнээр авч их хэмжээгээр нийт 100.4 сая төгрөгийн бэлэн мөнгөний зарцуулалт хийсэн, дараа тайлан болон бусад авлагын тооцоог бэлнээр авсныг банканд дахь харилцах дансанд тушаагаагүй байгаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн “20.2.3.холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах,” гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаагүй, “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Төлбөр тооцоог бэлэн бусаар хийж байх, дараа тайлан болон бусад авлагын тооцоог банкинд дахь дансанд тушааж байх.

2. Дотоод хяналтын үйл ажиллагаатай холбоотой асуудал:

2.1 Илрүүлэлт:

2021 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого хийж, тооллогын бүртгэл үйлдсэн боловч 1,244.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 85.1 сая төгрөгийн бараа материалын тооллогын бүртгэлд тооллогын комиссын зарим гишүүд гарын үсэг зураагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн “12.1.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна. 12.2.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;” 20 дугаар зүйлийн “20.2.3.холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;” гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаагүй, “үнэн зөв байх”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4 бүлгийн 4.4.3 дагуу гүйцэтгэж байх, тооллогын комиссын ажлын чанар, гүйцэтгэлд хяналт тавих

3. Дотоод хяналттай холбоотой асуудал:

3.1 Илрүүлэлт:

Эрчим хүчний яамнаас ирүүлсэн албан бичиг, тооцооллыг үндэслэн кассаас зарлага гаргасан баримтад мөнгө хүлээн авагчийн нэр тодорхойгүй, мөнгө хүссэн өргөдлийг холбогдох ажилтнаар бичүүлээгүй, хавсаргасан анхан шатны баримтууд хангалтгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5.Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно..., 13.6.Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаагүй, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Кассын үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4 бүлгийн 4.1.1 дагуу хөтлөх, анхан шатны баримтыг бүрэн гүйцэт бүрдүүлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ	АХГ-2022/86/НА-СТА-ТӨА	Мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлтэй байхад ЭМНДШ-ийн 13.3 сая төгрөг, ХХОАТатвар 13.1 сая төгрөгийн өртэй гарсан байна.	Нийгмийн дааатгалын тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх	1	26,411.5					1	26,411.5				
2	“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ	АХГ-2022/86/НА-СТА-ТӨА	Тайлант хугацаанд банкн дахь харилцах данснаас 91.1 сая төгрөг бэлнээр авч их хэмжээгээр нийт 100.4 сая төгрөгийн бэлэн мөнгөний зарцуулалт хийсэн, дараа тайлан болон бусад авлагын тооцоог бэлнээр авсныг банкн дахь харилцах дансанд тушаагаагүй байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх	1	100,412.1								1	100,412.1	
3	“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ	АХГ-2022/86/НА-СТА-ТӨА	2021 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого хийж, тооллогын бүртгэл үйлдсэн боловч 1,244.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 85.1 сая төгрөгийн бараа материалын тооллогын бүртгэлд тооллогын комиссын зарим гишүүд гарын үсэг зураагүй байна	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС-2 хэрэгжүүлж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх	1	85,130.4								1	85,130.4	
4	“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ	АХГ-2022/86/НА-СТА-ТӨА	Эрчим хүчний яамнаас ирүүлсэн албан бичиг, тооцооллыг үндэслэн кассаас зарлага гаргасан. Мөн кассын зарлагын баримтанд мөнгө хүлээн авагчийн нэр тодорхойгүй, мөнгө хүссэн өргөдлийг холбогдох ажилтнаар бичүүлээгүй, хавсаргасан анхан шатны баримтууд хангалтгүй байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх	1	-								1	-	

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5	“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ	АХГ-2022/86/НА-СТА-ТӨА	Тайлант онд Барнаб ХХК-тай 75.6 сая төгрөг, Интернэшнл повер ХХК-тай 56.5 сая төгрөг, Ричвел инженеринг ХХК-тай 146.4 сая төгрөг нийт 278.5 сая төгрөгийн зөвлөх үйлчилгээний ажлыг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх	1	278,576.4						1	278,576.4				
6	“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ	АХГ-2022/86/НА-СТА-ТӨА	Тайланд онд бусдаар гүйцэтгүүлсэн ажил буюу мэргэжлийн үйлчилгээний зардлаас 98.4 сая төгрөгийн гэрээт ажлыг сонгон шалгаруулалт хийлгүй иргэдтэй шууд гэрээ байгуулсан байна	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх	1	98,447.5						1	98,447.5				
ДҮН					6	588,977.9	-	-	-	-	3	403,435.4	-	-	3	185,542.5	
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																	
1	“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ	АХГ-2022/86/НА-СТА-ТӨА	Шилэн дансны цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээх хэсэгт мэдээлэх орлого, зарлагын 14 гүйлгээний 107.9 сая төгрөгийн мэдээлэлийг байршуулаагүй байна.	Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх	1	107,932.7						1	107,932.7				
ДҮН					1	107,932.7	-	-	-	-	1	107,932.7	-	-	-	-	
НИЙТ ДҮН					7	696,910.5	-	-	-	-	-	511,368.1	-	-	3	185,542.5	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 383/20150055

Улаанбаатар хот

АХГ- 0022/86/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу хийсэн Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд бусдаар гүйцэтгүүлсэн ажил буюу мэргэжлийн үйлчилгээний зардлаас 98.4 сая төгрөгийн гэрээт ажлыг сонгон шалгаруулалт хийлгүй иргэдтэй шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно." гэсэн заалтыг зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах, гарсан алдаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын гүйцэтгэх захирал М.Түмэнжаргал, ахлах нягтлан бодогч Б.Роломжав нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ

Д.ЭХБАЯР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 384/АО/СООСС

Улаанбаатар хот

АХГ- 2022/86/МА-СТА-ТВА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу хийсэн Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Барнаб ХХК-тай 75,650,000.00 төгрөг, Интернэшнл повер ХХК-тай 56,550,000.00 төгрөг, Ричвел инженеринг ХХК-тай 146,426,359.93 төгрөг нийт 278,626,359.93 төгрөгийн зөвлөх үйлчилгээний ажлыг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно." гэсэн заалтыг зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах, гарсан алдаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын гүйцэтгэх захирал М.Түмэнжаргал, ахлах нягтлан бодогч Б.Роломжав нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ

Д.ЭХБАЯР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 385/20150055
АХГ-2022/86/НА-СТД ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу хийсэн Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Харилцах дансанд 1,136,242,535.53 төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байхад ЭМНДШ-ийн 13,355,726.00 төгрөг, ХХОАТ-аар 13,055,808.96 төгрөгийн өртэй гарсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 "Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ", "ХХОАТ-н тухай хуулийн Албан татварыг өөрөө тодорхойлж, төсөвт төлөх, 26 дугаар зүйлийн 26.1 "Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу албан татвар ногдуулах орлогоо өөрөө үнэн зөв тодорхойлж, доор дурдсан хугацаанд албан татварыг холбогдох төсөвт төлнө: 26.1.1 энэ хуулийн 15.1, 16.1.1, 17.1.2, 17.1.3-т тодорхойлсон орлогод энэ хуулийн 21.2.4-т заасан хувиар тооцон тухай бүр албан татвар ногдуулан, дараа сарын 15-ны өдрийн дотор, 26.1.4 "Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн татварын жилд гадаад улсад олсон энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд тодорхойлсон орлогод энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Нягтлан бодох бүртгэлийн тухай, Нийгмийн даатгалын тухай болон ХХОАТ-ын тухай хуулиудыг мөрдөж ажиллах, гарсан алдаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын гүйцэтгэх захирал М.Түмэнжаргал, ахлах нягтлан бодогч Б.Роломжав нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Д.ЭХБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0315_Auditin_2_Gazar-57.Docx

0010801095



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 326/20150055
АХГ-2022/26/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу хийсэн Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд нийт 3,668,120,308.26 төгрөгийн ажил, гүйлгээний 199 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулахаас 107,932,731.00 төгрөгийн ажил, гүйлгээний 14 мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, "6 дугаар зүйлийн 6.4.4 "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг," гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах, мэдээллийг тогтоосон хугацаанд иж бүрэн байршуулах, гаргасан алдаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ-ын гүйцэтгэх захирал М.Түмэнжаргал, ахлах нягтлан бодогч Б.Роломжав нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц. ХОСЖАРГАЛ

Д.ЭХБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Aulltin 2 Gazar-58.Docx

0010801097